



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 9 нэрийн, нийт 102,425,218.00 /нэг зуун хоёр сая дөрвөн зуун хорин тавин мянга хоёр зуун арван найм/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга Ч.Тавинжилд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201015

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



**Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалт анд орсон огноо	Хэмжи х нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1.АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ						
1	Мотоцикль	2012-12-28	ш	5	1,150,000.00	5,750,000.00
	Хэсгийн дүн			5		5,750,000.00
2. МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /КОМПЬЮТЕР/						
2	Насос /худгийн/ 1.1kBt	2017-05-15	ш	3	331,650.00	994,950.00
3	Насос /худгийн/ 0.5кВт	2017-05-15	ш	4	258,500.00	1,034,000.00
4	Насос /худгийн/ 0.75кВт	2017-05-15	ш	4	297,000.00	1,188,000.00
5	Мотор /худгийн Akula3800/	2017-05-15	ш	22	841,500.00	18,513,000.00
6	Бага оврын трактор	2010-12-31	ш	9	2,494,952.00	22,454,568.00
	Хэсгийн дүн			42		44,184,518.00
3. БУСАД ҮНДСЭН ХӨРӨНГӨ						
7	Торон хайс /Бэлчээрийн/	2010-02-28	ш	1	1,327,500.00	1,327,500.00
8	Торон хайс /25 га/	2010-02-28	ш	1	12,181,715.00	12,181,715.00
9	Торон хайс /80 га/	2010-02-04	ш	1	38,981,485.00	38,981,485.00
	Хэсгийн дүн			3		52,490,700.00
НИЙТ ДҮН				50		102,425,218.00 /нэг зуун хоёр сая дөрвөн зуун хорин тавин мянга хоёр зуун арван найм/